



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/84

Булган сум

### “Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс мөн оны 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, сумын шуурхай штаб, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сум, багийн Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.

3.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох агентлаг, байгууллагын дарга, сумын Засаг дарга нарт даалгасугай.

3.1.Мал аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдал, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор “Малчдадаа тусалъя аян”-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Н.Батжаргал), Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Ганболд), сумын Засаг дарга нарт,

3.2.Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх, шар усны үерт өртөж болзошгүй малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Онцгой байдлын газар (хурандаа Ш.Баасандорж), сумын Засаг дарга нарт, шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлж ажиллахыг Цэргийн штаб (дэд хурандаа Ч.Энхбаяр), Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Булган аймаг дахь салбар төв (Н.Баасанжаргал) Булган АЗЗА ТӨХК (Э.Пүрэвдэмбэрэл) нарт,

3.3.Малын сэг, зэм устгахад шаардагдах ариутгал, халдваргүйтгэлийн бодис, гоц халдварт өвчний вакцин, шаардлагатай эм бэлдмэлийн нөөц бүрдүүлэх, татан авах, сумдад хүргэх ажлыг шуурхай зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т,

3.4.Олон улсын байгууллага, гадаадын төсөл хөтөлбөртэй хамтран малчдад туслах арга хэмжээ зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай), Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), Улаан загалмайн хороо (Д.Ууганбаяр) нарт,

3.5.Малчдыг эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд бүрэн хамруулах ажлыг 2024 оны 06 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулах, сумын эрүүл мэндийн төвийн алсын дуудлагад явах туулах чадвар сайтай эмнэлгийн тусламж үйлчилгээний автомашиныг хангалтыг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг), Нэгдсэн эмнэлэг (М.Бямбасүрэн) нарт,

3.6.Амьжиргааны эх үүсвэрээ алдаж, малгүй болсон малчдын судалгааг нарийвчлан гаргаж, малжуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулах арга хэмжээ авахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг), Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар (Н.Батжаргал), сумын Засаг дарга нарт,

3.7.Орон нутгийн төсвийн давсан орлогыг малчдад туслах арга хэмжээнд зарцуулах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт), сумын Засаг дарга нарт,

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Шуурхай штабын дарга, аймгийн Засаг даргын орлогч Д.Жаргалсайхан, Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Ш.Баасандорж нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ